АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН | 2024

2024 ОН

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУЗГ	Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар
АНТАГ	Аймаг, нийслэлийн төрийн аудитын газар
АНСДИТХ	Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОХГ	Байгаль орчныг хамгаалах газар
ЗХЭЗГ	Захиргаа хууль эрх зүйн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ДАХШҮГ	Дотоод аудит хяналт шинжилгээ үнэлгээний газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба
ХБТГ	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХНЖ	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт
ХАК	Хувийн аудитын компани
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХЭ	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

АГУУЛГА

	ТАЙЛАНТ ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА
	ХУРААНГУЙ ТАЙЛАН
I БҮЛЭГ:	УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
II БҮЛЭГ:	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
III БҮЛЭГ:	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
IV БҮЛЭГ:	НИЙЦЛИЙН АУДИТ
V БҮЛЭГ:	ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ
VI БҮЛЭГ:	ДОТООД АЖИЛ
VII БҮЛЭГ:	САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
VIII БҮЛЭГ:	ДҮГНЭЛТ, САНАЛ

АУДИТЫН ҮР ДҮН

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

257

175
Бие дааж дүгнэлт гаргасан

82
Түүвэрт Хамруулсан

ГҮЙЦЭТГЭЛ,НИЙЦЛИЙН АУДИТ

12

Хамрагдсан байгууллага
311

АУДИТЫН САНАЛ ДҮНЭЛТ

115
Өөрчлөлтгүй

56
Хязгаарлалттай

3
Татгалзсан

1
Сөрөг

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн үр өгөөж
11,765.5 сая төгрөг
264

28
Сургалт

13 нийт албан хаагч

Аудитын илрүүлэлт
92,131.7 сая төгрөг
766

Төлбөрийн акт
176.8 сая төгрөг
66

Албан шаардлага
77,705.8 сая төгрөг
430

Зөвлөмж
1,041.1 сая төгрөг
151

Сахилгын шийтгэл ногдуулах
319.7 сая төгрөг
19

Залруулсан алдаа
12,888.3 сая төгрөг
100

ТАЙЛАНТ ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэд олон нийт харилцагч талуудын хамтын ажиллагааны хүрээнд:

- ✓ Төрийн аудитын байгууллагын 2024 онд дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцагч талуудын оролцоо, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний аудитын газар нь Архангай аймаг дахь төрийн аудитын газартай хамтран "ТӨРИЙН АУДИТ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг иргэд, олон нийтийн дунд зохион байгуулав.
- ✓ Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах" зорилтын хүрээнд шийдвэрийн хэрэгжилтийг үр дүнтэй хангуулах сарын аяныг зохион байгуулж, аймгийн ИТХ-ын дэргэдэх Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хорооны гишүүдтэй уулзалт хийн үйл ажиллагаагаа танилцуулан, гүйцэтгэсэн аудитын талаар мэдээлэл өглөө.
- ✓ Иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх "**Цахим нээлттэй хаалганы өдөрлөг**"-ийг зохион байгуулаа.

Аудитын хүрээнд:

- ✓ "ОНХС-ийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн,үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар нийслэл, 21 аймгийн судалгаа, тайланг нэгтгэн улсын хэмжээний нэгдсэн тайланг бичиж, Сангийн яамнаас санал авахаар хүргүүлэв.
- ✓ ТАБ-ын хэмжээнд урьд өмнө нь хийгдэж байгаагүй онцлог сэдэвтэй "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийлээ.
- ✓ Улс, орон нутгийн ээлжит сонгуультай холбоотой 6 аудитыг гүйцэтгэв.

Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд:

- ✓ Бриллиант эмнэлэгт байгууллагын ажилтан, алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэг, шинжилгээнд хамруулаа.
- ✓ Аймгийн засаг даргад байгууллагын албан конторын барилгын газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулаа.

ХУРААНГУЙ ТАЙЛАН

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/172 дугаар тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах жил" гэж тодорхойлон баталсан. Энэхүү зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дэд төлөвлөгөөг дарга, тэргүүлэх аудиторын А/20 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тус ажлын төлөвлөгөөнд аудитын дүнгээс өгсөн шийдвэр, хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг аймгийн Засаг дарга болон ИТХ-д хүргүүлж, биелэлт үр дүнг бүрэн хангуулахад хамтран ажиллахаар тусгасны дагуу 2024 оны 3 дугаар улирлын байдлаар Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн аудитын дүнгээр илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгуулахаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн тайланг аймгийн ИТХ-д хүргүүлж, хамтран ажиллалаа.

Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг МУЕА-ын 2023 оны А/01 дүгээр тушаалаар баталсан "ТАБ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх журам"-ын дагуу боловсруулан МУЕА-аар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллав. Төлөвлөгөөний дагуу 2024 онд 9 чиг үүрэг, 12 зорилтын хүрээнд нийт 39 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2024 онд 38 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 1 арга хэмжээ 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрх болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу нийт 257 байгууллагын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит, МУЕА-ын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэлийн 5, нийцлийн 7 аудит, нийт 269 аудитыг бүрэн хийж гүйцэтгэлээ. *Аудитын дэлгэрэнгүйг тайлангийн 2,3,4 дүгээр бүлэгт дэлгэрэнгүйгээр оруулав.*



2024 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 92,131.7 сая төгрөгийн 766 алдаа, зөрчил илэрснээс бүртгэл тайлагналтай холбоотой 12,888.3 сая төгрөгийн 100 алдааг аудитын явцад залруулж, 176.8 сая төгрөгийн төлбөрийн 66 акт, 77,705.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах 430 албан шаардлага, 319.7 сая төгрөгийн 19 албан тушаалтанд хариуцлага тооцох, 1,041.1 сая төгрөгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах 151 зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Аудитын нийт илрүүлэлтийн 71.5 хувь буюу 65,831.8 сая төгрөг нь гүйцэтгэлийн аудитаар, 22.5 хувь буюу 20,703.4 сая төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитаар, 6.0 хувь буюу 5,596.6 сая төгрөг нь нийцлийн аудитаар илэрсэн байна.

Төлбөрийн актын хэрэгжилт: Нийт төлбөрийн актын 98.5 хувь буюу 175.6 сая төгрөгийн 65 төлбөрийн актын хэрэгжилтийг хангуулж, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт хугацаа хэтэрсэн байна.Өмнөх оноос 22.9 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулсан.

Албан шаардлагын хэрэгжилт: Нийт албан шаардлагын 92.3 хувь буюу 72,010.3 сая төгрөгийн 399 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 5,695.4 сая төгрөгийн 31 албан шаардлагын хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна. Сахилгын шийтгэл ногдуулах 319.7 сая төгрөгийн 19 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулав.



Зөвлөмжийн хэрэгжилт: Нийт зөвлөмжийн 89.4 хувь буюу 1,041.1 сая төгрөгийн 135 зөвлөмжийн биелэлтийг хангуулж,16 зөвлөмжийн хугацаа болоогүй хэрэгжих шатанд байна.

Аудитын үр өгөөж:

Аудитаас нийт 11,765.5 сая төгрөгийн 264 санхүүгийн үр өгөөж, 59 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлснээс 2,057.6 сая төгрөгийн 2, санхүүгийн бус 1 үр өгөөж нь өмнөх онд гүйцэтгэсэн аудитын үр дүнд бий болсон байна. Хүлээн зөвшөөрүүлсэн санхүүгийн үр өгөөжийг 2024 оны санхүүжилтийн дүн 964.5 сая төгрөгтэй харьцуулахад нэг төгрөгийн санхүүжилтэд **12.2** төгрөгийн үр өгөөж ногдож байна.

БҮЛЭГ- I

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь дарга, тэргүүлэх аудитор-1, аудитын менежер-1, ахлах аудитор-3, аудитор-7, жолооч-1 нийт 13 албан хаагчтайгаар ажиллаж байна.

Нийт албан хаагчдыг насаар ангилж авч үзвэл 25-35 насны 7, 36-45 хүртэлх насны 4, 45-аас дээш насны 2 албан хаагч, харин хүйсээр авч үзвэл эрэгтэй 4, эмэгтэй 9 албан хаагч байна.

Үндсэн орон тооны 13 ажилтны 69.2 хувь нь тус газарт 5-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд нийт албан хаагчдын 38.5 хувь нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй, 46.1 хувь нь магистр цолтой байна.

Албан хаагчдыг мэргэжил, боловсрол, ажилласан жил



Бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан нягтлан бодогч, бичиг хэрэг, аудиторын сул орон тооны 3 ажлын байрны зарыг байгууллагын цахим хуудаст нээлттэйгээр байршуулан ирүүлсэн материалыг хүлээн авч 2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 01/461 дүгээр албан бичгээр 5 иргэний материалыг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

Нярав жолоочийн сул орон тооны нээлттэй ажлын байрны зарыг байгууллагын цахим хуудаст байршуулан ажлын хэсэг байгуулан Дарга тэргүүлэх, аудиторын 2024 оны Б/14 дүгээр тушаалаар Ж.Дэмидийг нярав, жолоочийн ажилд томилсон байна.

Төрийн аудитын, Төрийн албаны тухай хуулиуд болон Төрийн албан хаагчийн үр дүнг үнэлэх шагнаж, урамшуулахтай холбоотой Засгийн газрын тогтоол, ТАБ-ын дотоод журмыг үндэслэн 2024 онд 3 албан хаагчийг Төрийн дээд одон медалиар, 10 албан хаагчийг Засгийн газрын болон салбарын шагналаар, 1 албан хаагчийг ҮАГ-ын шагналаар шагнуулахаар давхардсан тоогоор 14 саналыг МУЕА-д уламжилж холбогдох байгууллагууд шийдвэрлүүлэхээр хүргүүлж, төрийн дээд одон медалиар 2, Засгийн газрын шагнал салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр 3, Сангийн яамны жуух бичгээр 4 хүн, нийт 9 албан хаагч шагнагдсан байна.

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан албан хаагчдыг хөгжүүлэх, тэдний нийгмийн баталгааг хангах зорилгоор байгууллагын 2024 оны “Дотоод ажлын төлөвлөгөө”, “Сургалтын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БҮЛЭГ- II

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

2024

ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА

257

- **175** БИЕ ДААЖ ДҮГНЭЛТ ГАРГАСАН
- **82** ТҮҮВЭРТ ХАМРУУЛСАН

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

115	56	3	1
ӨӨРЧЛӨЛТГҮЙ	ХЯЗГААРЛАЛТТАЙ	ТАТГАЛЗСАН	СӨРӨГ

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ, төрлөөр

НИЙТ ИЛРҮҮЛЭЛТ	АЛБАН ШААРДЛАГА	ТӨЛБӨРИЙН АКТ
20,703.3 сая төгрөг	6,285.9 сая төгрөг	168.3 сая төгрөг

ЗӨВЛӨМЖ (тоо)	ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ (тоо)	ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН
126	19	168.3 сая төгрөг

САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ	САНХҮҮГИЙН БУС ҮР ӨГӨӨЖ
4,537.9 сая төгрөг	36

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А/75 дугаар тушаал, дарга тэргүүлэх аудиторын 2023 оны 09 дүгээр сарын 05-ны А/37 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу 257 төсөв захирагч, байгууллага, аж ахуйн нэгжийн 2023 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглаварт хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитад ТАГ-ын үндсэн 9 аудитор, 2 ХАК оролцон, аудитын менежер болон Тэргүүлэх аудитор аудитыг хянан удирдаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлэн 3,360 хүн өдөр, 2,503 илүү цаг зарцуулан ажиллав. Нэг аудитор дунджаар 15 төсөв захирагчийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж ажилласан байна.

Аудитаас 82 байгууллагыг түүвэрчилсэн байдлаар аудитад хамруулан шалгаж, 175 байгууллагад бие даасан санал дүгнэлт Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу 79 байгууллагын санхүүгийн тайланг аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн.

Нийт санал дүгнэлтийн 65.7 хувь буюу 115 тайланд "Зөрчилгүй", 32.0 хувь буюу 56 тайланд "Хязгаарлалттай", 1.7 хувь буюу 3 тайланд "Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан", 0.6 хувь буюу 1 тайланд "Сөрөг" дүгнэлтийг хүргүүлсэн байна. Өмнөх онтой харьцуулахад "Хязгаарлалттай" болон санал "Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан" дүгнэлт өссөн үзүүлэлттэй байна.

Аудитаар нийт **20,703.3** сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад математик тооцоолол алдсан, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэн, мэдээллийг тусгаагүй орхигдуулсан болон буруу тусган илэрхийлсэн зэрэг нийт **12,888.3** сая төгрөгийн 100 алдааг илрүүлэн, шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.Нийт илрүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал 12.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Залруулагдаагүй **7,815.0** сая төгрөгийн **527** зөрчлөөс **6,285.9** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах **319** албан шаардлага, **1,041.1** сая төгрөгийн зөрчилд **126** зөвлөмж, **168.3** сая төгрөгийн төсөвт

буцаан төвлөрүүлэх **63** төлбөрийн акт, **319.7** сая төгрөгийн зөрчил гаргасан **19** албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг шалгагдагч байгууллагад хүргүүлэн ажиллав.

Төлбөрийн акт хэрэгжилт: Аудитаар нийт 168.3 сая төгрөгийн 63 төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг 100 хувь хангууллаа.

Албан шаардлагын хэрэгжилт: Аудитаар нийт 6,285.9 сая төгрөгийн 319 албан шаардлага хүргүүлснээс 99.7 хувь буюу 6,278.0 сая төгрөгийн 318 албан шаардлагыг хэрэгжилтийг хангуулж, 7.9 сая төгрөгийн 1 албан шаардлагын хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна.

Аудитаар сахилгын шийтгэл ногдуулах 18 албан шаардлага хүргүүлснээс 319.7 сая төгрөгийн 18 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, сүүлийн хагас жилд аудитаас өгсөн албан шаардлагын хугацаанд нь биелүүлээгүй 1 төсөв захирагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг холбогдох холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж биелэлтийг хангууллаа.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар нийт 1,041.1 сая төгрөгийн 126 зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг бүрэн хангуулан ажиллалаа.

Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж: 2023 санхүүгийн тайлангийн аудитаар нийт **7,815.0** сая төгрөгийн 527 шийдвэрийн хэрэгжилтийг хангуулснаас **4,537.9** сая төгрөгийн 241 санхүүгийн, 36 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн бүртгэлээ.

АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн ТЕЗ-ийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэсэн. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын ТТЗ-ийн 19, төсвийн шууд захирагчдын 50, төсөл сангийн 41, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 10, нийт 120 санхүүгийн тайлан болон аймгийн Засаг дарга, барьцаа хөрөнгө, техник хяналт зэрэг зардлын дансны гүйлгээ нэгтгэгдсэн бөгөөд санхүүгийн тайлангийн нэгдсэн судалгаа, тулгалтыг хийн санхүүгийн нэгтгэсэн тайланг баталгаажуулж ажиллав.

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг үнэлж Архангай аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “**Зөрчилгүй**” санал дүгнэлтийг гардуулан өгөв.

Аудитын үр дүн:

Аудитаар нийт 965.3 сая төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс 656.5 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн залруулж, 308.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох, засаг даргын зүгээс тодорхой арга хэмжээг авч, хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах 3, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага, 5 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангууллаа.
Аудитаас 308.8 сая төгрөгийн 2 санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд аймгийн ТЕЗ-ийн 2023 оны жилийн төсвийн гүйцэтгэлд аудитыг хуулийн хугацаанд хийж тайланг аймгийн ИТХ, Засаг дарга болон ҮАГ-т хүргүүллээ.

Аймгийн ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд нийт 198 байгууллагын төсвийн гүйцэтгэл нэгтгэгдсэн бөгөөд төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нэгдсэн судалгаа, тулгалтыг хийж аймгийн ТЕЗ-аас тайлагнасан орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого 55,322.4 сая төгрөг, нийт зарлага 55,072.7 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулав.

Аудитын үр дүн:

Аудитын дүнд үндэслэн нийт 100.6 сая төгрөгийн алдаа зөрчилд дараах 4 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ-ын дарга, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, биелэлтийг хангуулснаар төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулан, хандиваар бий болсон өмч хөрөнгийг бүртгэл тайланд тусгуулж, бүртгэл хяналттай болголоо.

СУМЫН ТТЗ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан цаглаварт хугацаанд 19 сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, нийт санал дүгнэлтийг 63.2 хувь буюу 12 сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд “Өөрчлөлтгүй”, 36.8 хувь 7 сумын тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүллээ.

Аудитын үр дүн:

Аудитаар 1,770.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 269.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 19.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 999.7 сая төгрөгийн зөрчилд 14 албан шаардлага, 482.2 сая төгрөгийн 23 зөвлөмж, албан үүргээ биелүүлээгүй, зөрчил дутагдал гаргасан 4 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, биелэлтийг хангуулав.

Аудитын дүнд үндэслэн сумын төсвийн орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж, бодит тоо мэдээнд тулгуурлан орлогын төлөвлөлтийг хийх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн олон жилийн насжилттай зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч, эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллах албан шаардлага, зөвлөмжийг бүх сумын Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан.

Аудитаас 493.7 сая төгрөгийн 15 санхүүгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

ТБОНӨХЭ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн дагуу 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд орон нутгийн өмчит 9, төрийн өмчит 2 хуулийн этгээд нийт төрийн болон орон нутгийн өмчит 11 хуулийн этгээдийг хамруулж, 10 хуулийн этгээдэд бие даасан дүгнэлтийг хүргүүлэн, 1 хуулийн этгээдийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

Аудитаас төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 1 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 6 тайланд “Хязгаарлалттай”, 1 тайланд “Сөрөг”, 2 тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” санал дүгнэлтийг хүргүүлэв.

Аудитын үр дүн:

Аудитаар нийт 872.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 86.3 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулан, 3.8 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 611.2 сая төгрөгийн зөрчилд 25 албан шаардлага, 74.8 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмж өгч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллаагүй 96.8 сая төгрөгийн зөрчил гаргасан 6 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг хангуулан ажиллалаа.

Аудитаас орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь эдийн засгийн зорилтод түвшинд хүрч, үр ашигтай ажиллах үндсэн зарчмаа хангаагүй, авлага, өр төлбөр үүсгэсэн, дотоод хяналт хариуцлага сул, нягтлан бодох бүртгэл тайлагнал хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэнд холбогдох арга хэмжээг авч ажиллах аудитаас холбогдох арга хэмжээг авч ажиллах албан шаардлага зөвлөмжийг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагууд болон аймгийн засаг даргад хүргүүлсэн.

Аудитаас 478.6 сая төгрөгийн 14 санхүүгийн үр өгөөж, 10 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд нийт 223 төсвийн шууд захирагчдын тайланг аудитад хамруулан, 81 тайланг түүвэрт хамруулан, 142 тайланд бие даасан санал дүгнэлт гаргалаа. Нийт санал дүгнэлтийн 98 тайланд “Зөрчилгүй”, 43 тайланд “Хязгаарлалттай”, 1 тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтийг шалгагдагч байгууллагад хүргүүллээ.

Аудитын үр дүн:

Аудитаар нийт 16,961.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 11,876.4 сая төгрөгийн 91 алдааг санхүүгийн тайланд залруулан, 144.7 сая төгрөгт 59 төлбөрийн акт тогтоож, 4,333.7 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, таслан зогсоох 275 албан шаардлага, 383.5 сая төгрөгийн зөрчилд 82 зөвлөмж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаагүй 222.9 сая төгрөгийн зөрчил гаргасан 7 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 100 хувь хангуулаад байна.

Аудитаас 3,224.2 сая төгрөгийн 208 санхүүгийн үр өгөөж, 23 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглаварт хугацаанд аймгийн Халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Нийгмийн даатгалын сан нийт 3 сангийн санхүүгийн тайланд аудит хийж, “**Зөрчилгүй”** санал дүгнэлтийг хүргүүллээ.

Аудитын үр дүн:

Аудитаар нийт 32.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 2 албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан үр өгөөжөөр тооцлоо.

ЗАВСРЫН АУДИТ

МУЕА-ын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” А/52-01 дүгээр тушаалд үндэслэн дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний А/32 дугаар тушаалаар завсрын аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийг баталж, завсрын аудитыг эхлүүллээ.

2023-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 85 байгууллагыг аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлэхээр хуваарилсны дагуу ТАГ нь Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу Бизкон аудит ХХК-ний Архангай салбар болон Шинжлэн магадлахуй аудит ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

Аудитын нээлтийг 2024 оны 09 дүгээр сарын 9-11-ний хооронд танхим болон цахимаар хийж, аудитын төлөвлөгөө, хуваарь, аудит хийх багийн бүрэлдэхүүнийг танилцуулан, 2023-2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийтлэг алдаа зөрчил, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлэхэд анхаарах асуудлын талаар мэдээлэл хийлээ. Нээлтэд ТАГ-ын аудиторууд, 2 аудитын хуулийн этгээд, аймаг, сумдын төсөв захирагчид, санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нар оролцлоо.



2024 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 218 байгууллагын аудитын урьдчилсан болон төлөвлөх үе шатны ажлыг МУЕА-ын А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал”-ын Fas.audit.mn системээр гүйцэтгэжээ. Дарга, тэргүүлэх аудиторын баталсан удирдамжийн дагуу 2024.12.12-12.20-ны хооронд Цэнхэр, Төвшрүүлэх, Өгийнуур, Хотонт, Хашаат сумдад нийт 25 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийлээ.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

БҮЛЭГ- III

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН 2024

ХАМРУУЛСАН БАЙГУУЛЛАГА

- ШАЛГАГДАГЧ 114
- ХАМРАГДАГЧ 87

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

5

- ХУУЛИЙН ДАГУУ 2
- БОДЛОГООР 3

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ, төрлөөр

НИЙТ ИЛРҮҮЛЭЛТ	АЛБАН ШААРДЛАГА	ТӨЛБӨРИЙН АКТ
65,831.8 сая төгрөг	65,825.1 сая төгрөг	6.7 сая төгрөг

ЗӨВЛӨМЖ (тоо)	САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ	ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН
21	5,167.5 сая төгрөг	5.5 сая төгрөг

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцооны үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад тулгуурлан тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 65,831.8 сая төгрөгийн 116 зөрчил илэрснээс 6.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 65,825.1 сая төгрөгийн зөрчилд 94 албан шаардлага, 21 заалт бүхий зөвлөмж, нэгтгэсэн тайланд тусгуулах 4 саналыг хүргүүлж ажиллав.

Төлбөрийн актын хэрэгжилт: Аудитаар нийт 6.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосноос 82 хувь буюу 5.5 сая төгрөгийг барагдуулаа.

Албан шаардлагын хэрэгжилт: Аудитаар нийт 65,825.1 сая төгрөгийн 94 албан шаардлага хүргүүлснээс 73.4 хувь буюу 65,723.2 сая төгрөгийн 69 албан шаардлагыг хэрэгжилтийг хангуулж, 27.9 сая төгрөгийн 19 албан шаардлагын хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар нийт 21 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснээс тайлант жилд 23.8 хувь буюу 5 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, 16 зөвлөмжийн хугацаа болоогүй хэрэгжих шатандаа байна.

Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж: Гүйцэтгэлийн аудитаар 5,167.5 сая төгрөгийн 15 санхүүгийн, 19 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Аудитын сэдэв батлах тухай”, 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн нийслэл, 21 аймгийн улсын хэмжээний ОНХС-ийн тайлан, судалгааг нэгтгэлээ. Нэгдсэн тайланд аудитын зөвлөлийн гишүүдийн санал зөвлөмжийг тусган 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Сангийн яамнаас санал авахаар хүргүүллээ. Аудитаас “*Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн төсвийг батлахдаа иргэдийн саналгүй, өргөн мэдүүлсэн төсөл, арга хэмжээг өөрчлөн баталж байгаад чиглэсэн хариуцлагын тогтолцоо бүрдээгүй байна”* гэсэн ерөнхий дүгнэлтийг өглөө.

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвх оролцоо, мэдээлэл ямар байгааг судлах, нэгтгэн дүгнэж аудитын тайланд тусган холбогдох

албан тушаалтнуудад танилцуулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг боловсруулах зорилгоор гүүгл форум (google forum) ашиглан 21 асуултын хүрээнд 21 аймаг, нийслэлийн нийт 7,694 иргэнээс цахимаар, 361 иргэнээс цаасаар саналыг авч нэгтгэн дүн шинжилгээ хийж, тайланд тусгав.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **162,768.3** сая төгрөгийн зөрчил илэрсэнд АНТАГ-аас **550.8** сая төгрөгийн **62** төлбөрийн акт, **76,245.0** сая төгрөгийн зөрчилд **384** албан шаардлага, **85,908.7** сая төгрөгийн зөрчилд **523** зөвлөмж, **63.8** сая төгрөгийн зөрчлийг шалгуулахаар хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт 1, Сангийн яаманд 4, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д 1, Засаг даргад 2 зөвлөмжийг хүргүүллээ.

УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛСАН АСУУДАЛ:

Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг бүсчлэн нэгдсэн байдлаар тогтоож Төсвийн тухай хууль болон Малын тоо толгойн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлыг авч хэлэлцэх

УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд “Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж 36 хүн өдөр зарцуулав.

Аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар Архангай аймагт хэрэгжүүлсэн 287,579.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 109,899.1 сая төгрөгөөр санхүүжих дүн бүхий 50 төсөл, арга хэмжээний баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет горим хэрэгжүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэргээр шалгагдагч болон хамрагдагч 40 байгууллагыг хамруулан гүйцэтгэв.

Аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн 36 ТАХ-нд зориулж 70,637.4 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн ба ажлын гүйцэтгэлд үндэслэн 94.2 хувь буюу 66,514.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **58,128.1** сая төгрөгийн зөрчил илрүүлж, төсөвт буцаан төвлөрүүлэх **6.7** сая төгрөгийн **1** төлбөрийн акт, зөрчлийг арилгуулахаар **58,121.4** сая төгрөгийн **6** албан шаардлага, **2** заалт бүхий зөвлөмж хүргүүлэв. Өмнөх оны аудитын илрүүлэлтээс **2.9** дахин өссөн үзүүлэлттэй байна.

АУДИТЫН ҮР ДҮН:

1. Тайлант хугацаанд тогтоосон 6.7 сая төгрөгийн төлбөрийн актны 82 хувь буюу 5.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж санхүүгийн болон санхүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн.
2. Улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан 1,096.1 сая төгрөгийн 2 барилга байгууламжийн гүйцэтгэгчид комиссоос өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлэн хөрөнгийн ашиглалт сайжирч, иргэд, олон нийтийн хүртэх үр нөлөө дээшилсэн.
3. ХХААХҮС-аас эрх шилжин хэрэгжсэн “Малын үүлдэр угсааг сайжруулах төсөл”-ийн хүрээнд бий болсон мал амьтдыг түрээсээр ашиглуулах гэрээнд төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах үр ашиг дээшлүүлэх чиглэлийг баримтлан нэмэлт өөрчлөлт хийлгүүлж, хөрөнгийн хяналт, үр ашгийг сайжруулсан.
4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс нь гүйцэтгэгчид өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдаагүй барилгыг хүлээж авахгүй байх чиглэлийг баримтлаж, барилгын чанар, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан.
5. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй гүйцэтгэгч нарын гэрээг дүгнэж, хариуцлага тооцох, яаралтай ашиглалтад оруулах арга хэмжээг авч хэвшсэн.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аймаг дахь Төрийн аудитын газрын даргын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 02 дугаар сарын 26-аас 2024 оны 04 дүгээр сарын 19-ны хооронд гүйцэтгэж 36 хүн өдөр зарцууллаа.

Аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.

Аймаг, Эрдэнэбулган, Жаргалант, Хашаат сумын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 2,821.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 89.5 хувь буюу 60 төсөл, арга хэмжээнд 2,526.8 сая төгрөгийн, авто замын сангийн 2023 оны хөрөнгө оруулалтаар 1,106.9 сая

төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 85.5 хувь буюу 5 төсөл, арга хэмжээнд 946.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет горим хэрэгжүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэргээр шалгагдагч болон хамрагдагч 17 байгууллагыг хамруулан гүйцэтгэв.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,526.8 сая төгрөгийн 60 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн

Аудитаар 2,586.3 сая төгрөгийн зөрчилд 16 албан шаардлага хүргүүлэв.

АУДИТЫН ҮР ДҮН:

1.Эрдэнэбулган сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд ГХБХБГ-тай гэрээ байгуулан захиалагчийн үе шатны болон байнгын хяналтыг хэрэгжүүлж хэвшсэн нь төсвийн хөрөнгийн чанар, үр дүнг сайжруулсан.

2. Аймаг, сумдын орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 446.5 сая төгрөгийн их засварын 9 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгуулсан нь хөрөнгийн хадгалалт хамгаалалт сайжрах нөхцөл бүрдсэн.

3.Сумдын орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохдоо журмын дагуу батлагдсан хяналтын хуудсыг хөтлөж хэвшсэн нь төсвийн хөрөнгийн хяналт сайжирч, анхан шатны баримтын иж бүрдэл хангагдсан байна.

4.Аудитаар 2,327.3 сая төгрөгийн 4 санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

5.Аймгийн Засаг даргын 2024 оны 06 сарын 05-ны өдрийн А/419 тоот захирамжаар 2024 онд авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын явц үр дүнд хяналтыг хэрэгжүүлэх 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан нь төсвийн хөрөнгөнд тавих хяналт сайжирсан байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/152, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 05 дугаар сарын 14-өөс 2024 оны 07 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж 38 хүн өдөр зарцуулав.

Аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/22 дүгээр тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд 2023 онд ОНХС-ийн эхний үлдэгдэл 2,976.4 сая, тайлант онд нийт 16,105.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 447 төсөл арга хэмжээг 12,341.7 сая төгрөгөөр санхүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталж, гүйцэтгэл 12,226.4 сая төгрөг буюу 75.9 хувьтай байна. ОНХС-ийн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 3,091.8 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **5,079.1** сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар **5,079.1** сая төгрөгийн **45** албан шаардлага, **3** заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн.

АУДИТЫН ҮР ДҮН:

1. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар аймгийн ОНХС-д бүрдүүлэх 239.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн.
2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн 269.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэбулган сумын 6 дугаар багийн “Мал нядалгааны цэг”, 647.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, 98.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хотонт сумын Наадмын талбай” нийт 1,015.7 сая төгрөгийн 3 ТАХ-г ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгуулсан.
3. Тариат сумын 2023 оны ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Гудамж талбайн тохижилт, замын тэмдэг тэмдэглэгээ" хийх 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-г ашиглагч байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгуулсан.
4. Хашаат сумын 2023 оны ОНХС-ын хөрөнгөөр шинээр хэрэгжүүлсэн 149.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Халуун усны барилга"-ын ажил болон Цагаан хад, Цайдам багуудад гаргасан 36.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй худгийн цооногийн ажлуудад түрээслэгч иргэдтэй төрийн өмчийн ашиглалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулсан.
5. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд аймаг, сумын ИТХ-аас хяналт хэрэгжүүлж хэвшсэн байна.

Аудитаар 1,588.6 сая төгрөгийн 8 санхүүгийн, 8 санхүүгийн бус үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж 54 хүн өдөр зарцуулав.

Аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/39 дугаар тушаалаар баталгаажуулан

ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.

Архангай аймгийн хэмжээнд 2019-2023 онд хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээнд нийт 437.5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс олгосон ба зарцуулалтын анхан шатны баримт материалд дүн шинжилгээ хийх, газар дээр нь биет горим хэрэгжүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тодруулга, тайлбар авах зэргээр шалгагдагч болон хамрагдагч 11 байгууллагыг хамруулан гүйцэтгэв.

Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь 2019-2023 онд шуурхай тусламжийн үйлчилгээг 78 хүүхдэд үзүүлэн 23.8 сая төгрөг, хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээг 5954 хүүхдэд үзүүлэн 149.9 сая төгрөг, урьдчилан сэргийлэх үйлчилгээг 37470 хүүхдэд үзүүлэн 262.2 сая төгрөгийг тус тус зарцуулан, нийт 435.9 сая төгрөгийг хүүхдэд хамгааллын цогц үйлчилгээнд зарцуулан 1.6 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **10.3** сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар **10.3** сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, **7** зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

АУДИТЫН ҮР ДҮН:

1. Аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дэргэдэх түр хамгаалах байрны урсгал зардлыг аймгийн 2025 оны төсөвт тусган батлуулсан.
2. Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой мэдээллийн санг бүрдүүлж тухай бүр мэдээллийг шинэчилж хэвшсэн.
3. Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой анхан шатны баримт материалыг архивын нэгж болгон нөхөн бүрдүүлсэн.
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажлын хэсэг болон холбогдох албан тушаалтнууд нууцын баталгаа гаргаж хэвшсэн.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж 53 хүн өдөр зарцуулав.

Аудитын тайланг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/43 дугаар тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэв.Аудитаар аймаг, сумын нутгийн өөрөө удирдах 20, аймгийн Засаг даргын харьяаны төрийн захиргааны 26, боловсролын

салбарт харьяалагдах сургууль, цэцэрлэг 64, эрүүл мэндийн салбарт харьяалагдах 18 сумын ЭМТ, соёлын салбарт харьяалагдах 18 сумын Соёлын төв нийт 146 байгууллагын хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулж хэрэгжүүлсэн байдлыг 2013 оноос 2024 оны есдүгээр сарыг хүртэлх хугацааг хамруулав.

Архангай аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар нутгийн өөрөө удирдах 20 байгууллагад 62, аймгийн Засаг даргын харьяаны 26 байгууллагад 531, боловсролын салбарын харьяа ЕБС, СӨБ-ын 64 байгууллагад 2751, эрүүл мэндийн салбарын харьяа 18 сумын эрүүл мэндийн төвд 516, соёлын салбарын харьяа 18 сумын Соёлын төвд 158 нийт 146 байгууллагад 4017 төрийн албан хаагч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар ажиллаж байсан нийт 4017 төрийн албан хаагчийн 71.7 хувь буюу 2882 эмэгтэй, 28.3 хувь буюу 1136 нь эрэгтэй албан хаагч байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт **27.9** сая төгрөгийн 30 зөрчил илрүүлж, 27.9 сая төгрөгийн 19 зөрчилд 19 албан шаардлага, 9 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллагуудад, 2 саналыг ҮАГ-аар уламжлуулан ТАЗ, ЭМЯ-нд хүргүүллээ. Аудитын шийдвэр хэрэгжих шатандаа буюу хугацаа болоогүй байна.

НИЙЦЛИЙН АУДИТ

БҮЛЭГ- IV

НИЙЦЛИЙН АУДИТЫН ҮР ДҮН 2024

ХАМРУУЛСАН БАЙГУУЛЛАГА

- ШАЛГАГДАГЧ 74
- ХАМРАГДАГЧ 36

ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

7

- ХУУЛИЙН ДАГУУ 6
- БОДЛОГООР 1

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ, төрлөөр

НИЙТ ИЛРҮҮЛЭЛТ	АЛБАН ШААРДЛАГА	ТӨЛБӨРИЙН АКТ
5,596.6 сая төгрөг	5,594.8 сая төгрөг	1.8 сая төгрөг

ЗӨВЛӨМЖ (тоо)	САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ	ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН
4	2,060.1 сая төгрөг	1.8 сая төгрөг

НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитын чиглэлээр 2024 онд хуулийн дагуу 6, бодлогоор 1 нийт 7 аудитыг бүрэн гүйцэтгэв.

Төлбөрийн акт хэрэгжилт: Аудитаар нийт 1.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг бүрэн хангуулан ажиллалаа.

Албан шаардлагын хэрэгжилт: Аудитаар нийт 5,594.8 сая төгрөгийн 17 албан шаардлага хүргүүлснээс 64.7 хувь буюу 1.2 сая төгрөгийн 11 албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж, 5,593.6 сая төгрөгийн 6 албан шаардлагын хугацаа болоогүй буюу хэрэгжих шатандаа байна.

Зөвлөмжийн хэрэгжилт: Аудитаар 4 зөвлөмжийг хүргүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулав.

Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж: Тайлант онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар 2.5 сая төгрөгийн 6 санхүүгийн үр өгөөж, санхүүгийн бус 3, өмнөх оны аудитаас 2,057.6 сая төгрөгийн 2 санхүүгийн, санхүүгийн бус 1, нийт 2,060.1 сая төгрөгийн 8 санхүүгийн, санхүүгийн бус 4 үр өгөөжийг шалгагдагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүллээ.

1 Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нэг нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасны дагуу аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нэг нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг нийт ***552.5*** сая төгрөгөөр тогтоосноос аймгийн ИТХ-ын сонгуульд 345.3 сая төгрөг, сумын ИТХ-ын сонгуульд 207.2 сая төгрөг байна. Харин аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг аймагт нийт ***820.3*** сая төгрөг, суманд ***588.9*** сая төгрөгөөр тогтоолоо.

АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож Тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар баталгаажуулан байгууллагын албан ёсны пэйж хуудас болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээллээ.

2 Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө (2022,2023):

“Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр нөлөө” (2022,2023) сэдэвт өөрийн төлөвлөгөөт аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулан батлуулж, аудитын нээлтийг 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр холбогдох мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан хийлээ. Аудитад аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулсан, хэрэгжүүлсэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд болон 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт,

гүйцэтгэл, хяналт үнэлгээ, тайлагналын баримт материалыг хамруулан шалгалаа. Аудитаас "*Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 83.4 хувьтай*" гэж дүгнэсэн байна. Аудитын тайланг Тэргүүлэх аудиторын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/29 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүллээ.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн зөрчилд 6 албан шаардлага, 3 зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлсэн байна.

АУДИТЫН ҮР ДҮН:

1. Аудитаар хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийг хугацаанд хангуулж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бий болгож ажиллалаа.
2. "Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална" гэж заасны дагуу жилийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, батлуулахад арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийн дагу "Аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг боловсруулж, ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан байна.
3. Батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын цахим хуудас www.arkhangai.gov.mn сайтад байршуулж, иргэд олон нийтэд мэдээллийг хүргэн ажилласан байна.
4. Мөн аймгийн хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөөг богино болон дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 6 асуудлыг төлөвлөгөөнд тусган баталсан байна.
5. Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтод түвшин, хүрэх үр дүнг тодорхойлоогүй төсөл арга хэмжээг баталдаг зөрчлийг арилгаж 2025 оны аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд салбарын 21, ТЕЗ-ийн 28, хөтөлбөрийн 43 үр дүнг тодорхойлон баталсан.

3 Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргах:

Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.6, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргахаар төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулан ажиллалаа. Орон нутгийн сонгуульд оролцох 12 нам, 1 бие даагчаас ирүүлсэн сонгуулийн хөтөлбөрт хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргаж 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 342 тоот албан бичгээр аймгийн сонгуулийн хороонд хүргүүлж ажилласан.

АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.12-т заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийсэн аудитын дүгнэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр байгууллагын пэйж хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлж ажиллалаа.

4 Аймаг, сумын орон нутгийн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Аймаг нийслэл сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэгт заасны дагуу аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам эвсэл, бие даан нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргахаар төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулаа. Орон нутгийн сонгуульд оролцох 12 нам, 1 бие даагчийн хандивын тайланд дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.12-т заасны дагуу сонгуулийн хандивын тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр байгууллагын пэйж хуудсанд байршуулж олон нийтэд мэдээллээ.

5 Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудит:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаал, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулан батлууллаа. Аудитад аймгийн сонгуулийн хороо, 19 сумдын сонгуулийн хороо, 105 хэсгийн хороо, аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс хамрагдлаа. Аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр эхэлж, тайланг Тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 29-ны А/28 тоот тушаалаар баталгаажуулан ҮАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэн ажиллалаа. Аудитаас "*3.0 сая төгрөгийн зөрчил илэрснийг эс тооцвол УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу хуваарилж, зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан байна*" гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс төсвийг анхан шатны баримтгүй зарцуулсан **1.8** сая төгрөгийн зөрчилд **2** төлбөрийн акт тогтоож, **1.2** сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчилд **6** албан шаардлага, **1** зөвлөмжийг аймаг, сумдын сонгуулийн хороодод хүргүүлэн ажилласан.

АУДИТЫН ҮР ДҮН:

1. Аудитаар илэрсэн 21.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан бол 1.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 1.2 сая төгрөгийн 6 албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь хангуулан 2.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бий болгон хүлээн зөвшөөрүүлж ажиллалаа.
2. СЕХ-ны даргын 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/56 дугаар захирамжаар баталсан удирдамжийн дагуу "Сонгуулийн хороонд ажиллах ажилтны арга зүй" сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж сумын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласаны дүнд аймаг, сумын ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын гүйцэтгэлийн тайланг СЕХ-ний даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, тавих журам"-ын дагуу гүйцэтгэлийг тайлагнасан байна. Мөн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийн дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан.

6 Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаал, Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ. Аудитад аймгийн сонгуулийн хороо, 19 сумын сонгуулийн хороо, 105 хэсгийн хороо, аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтсийг хамруулав. Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024.10.10-ны өдөр эхлүүлж, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ҮАГ болон аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэн ажиллалаа.

АУДИТЫН ҮР ДҮН:

УИХ-ын 2024 оны сонгууль зохион байгуулахад улсын төсвөөс санхүүжүүлсэн зардпын гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох журмыг мөрдөж ажиллах тухай аудитаас хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласнаар аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлд тавих хяналт сайжирч тус аудитаар зөрчил дутагдал илрээгүй байна.

7 Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" 2023 оны 162 дугаар

тушаал, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ. Аудитын явцад Архангай аймгийн 2024 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2025 оны жилийн төсвийн санал, Сангийн яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ, ХБТХОХ, БОХГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээг хамруулаа. Аудитаас "*Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг аймаг хөгжүүлэх дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах шаардлагатай байна*" гэсэн ерөнхий дүгнэлтийг хийсэн байна. Аудитыг хугацаанд гүйцэтгэж Тэргүүлэх аудиторын 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/45 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон Засаг даргад хүргүүлж ажиллалаа.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт Аудитаар нийт 5,593.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд 5 албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт 2025 оны эхний хагас жилд тайлагнагдахаар хугацаатай байна.

8 Аймаг, сумын орон нутгийн сонгуульд оролцох нам, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, нийтэд мэдээлэх:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд заасны дагуу 4 намын 746 нэр дэвшигч, 1 бие даагч сонгуулийн зардлын дансаа бүртгүүлсэн байна. Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд Монгол ардын намын 463, Ардчилсан намын 463, Хүн намын 7, Иргэдийн оролцооны нэгдэл намын 1, Иргэний хөдөлгөөний намын 14, аймаг, суманд 1 бие даагч нийт 950 нэр дэвшигч оролцсон байна. Үүнээс аймаг болон сумын ИТХ-д давхар нэр дэвшсэн 8 иргэн байна. Хуульд заасны дагуу нийт 942 нэр дэвшигч зардлын дансаа нээлгэж, Төрийн аудитын байгууллагад бүртгүүлэхээс 742 нэр дэвшигч бүртгүүлж, 36 нэр дэвшигч зардлын данс нээлгэсэн боловч бүртгүүлээгүй, 164 нэр дэвшигч зардлын данс огт нээлгээгүй байна.

Сонгуулийн зардлын дансны мэдээллийг бүртгүүлээгүй нэр дэвшигчдийг жагсаалтаар гаргаж, хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3[3], Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12[4]- т заасны дагуу аймгийн Татварын газарт хүргүүллээ.

Сонгуулийн зардлын данс нээлгэсэн 778 нэр дэвшигч тайлан, дүгнэлт ирүүлэхээс 775 нь аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан баталгаажуулж, Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна. Харин сонгуулийн зардлын дансаа нээлгээгүй 164, дансаа нээлгэсэн боловч тайлангаа ирүүлээгүй 3 нийт 167 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй болно.

Сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нэр дэвшигчдийн жагсаалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3[3], Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22[6]-т заасны дагуу аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчид хүргүүллээ.

Аудитын хуулийн этгээдийн баталгаажуулсан 775 тайлангийн 34.8 хувь буюу 270 нэр дэвшигчийн тайлан нь мөнгөн дүнтэй, 65.2 хувь буюу 505 тайлан нь ямар нэгэн гүйлгээ гараагүй байна. Нэр дэвшигчид сонгуульд оролцохдоо ямар нэгэн зардал гаргахгүй оролцох боломжгүй бөгөөд тус зардлыг сонгуулийн зардлын дансаар дамжуулан сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулахгүй, хуульд тогтоомжийг мөрддөггүй зөрчил давтан гарсаар байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1[8]-д заасны дагуу орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нарт нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн мэдээллийг нэгтгэхэд 49 иргэн 71,004.2 мянган төгрөг, 4 хуулийн этгээд 17,000.0 мянган төгрөг, нийт 88,004.2 мянган төгрөгийн мөнгөн хандивыг 40 нэр дэвшигчид өгсөн байна.

Тус аудитын тайлагналын үе шатны ажил хийгдэж, үе шатны хяналтыг хийлгэн ажиллаж байгаа бөгөөд хөтөлбөрийн дагуу аудитыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор дуусгахаар төлөвлөн ажиллаж байна.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,593.6 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнд 5 албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт 2025 оны эхний хагас жилд тайлагнагдахаар хугацаатай байна.

АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналтыг хэрэгжүүлэн ажилласнаар 2024 оны шилэн дансны мэдээлэл байршуулалт эхний 10 сарын байдлаар 92.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчлийн тоо 75.3 хувиар, мэдээллийг байршуулаагүй зөрчлийн тоо 46.2 хувиар тус тус буурсан үр дүнг бий болгосон байна.

[8] 57.1.Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, үр дүнг тайлагнах:

Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэл болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан төрийн санхүү, төсөвтэй холбоотой иргэн хуулийн этгээдээс ямар нэгэн өргөдөл гомдол ирээгүй байна. Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой нийт 82 шийдвэр хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулж, хэрэгжилтийг фас системээр үнэлж байгууллагын статистик мэдээ, тайланд тусгалаа. Харин эрсдэлтэй гэж үзсэн 54 байгууллагын шилэн дансны цахим сайтад байршуулсан мэдээлэлд 2024 оны эхний 10 сарын байдлаар хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа. Хяналтаар байршуулбал зохих нийт 4593 мэдээллээс 92.9 хувь буюу 4268 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 2.8 хувь буюу 129 мэдээллийг хугацаа хоцроож, 4.3 хувь буюу 196 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэхүү аудитаар нийт 54 байгууллагын шилэн дансны цахим системийн хөтлөлтийг shilendans.gov.mn сайтаас 2024 оны 10 дугаар сарын байдлаар хянасан бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар үргэлжлүүлэн хяналт хийж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байгууллагуудад жилийн дүнгээр жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шийдвэр хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

АУДИТЫН ҮР НӨЛӨӨ

Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналтыг хэрэгжүүлэн ажилласнаар 2024 оны шилэн дансны мэдээлэл байршуулалт эхний 10 сарын байдлаар 92.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зөрчлийн тоо 75.3 хувиар, мэдээллийг байршуулаагүй зөрчлийн тоо 46.2 хувиар тус тус буурсан үр дүнг бий болгосон байна.

ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

БҮЛЭГ- V

МУ-ЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН 2024 ОНД БАТАЛСАН "А" ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

Тайлант хугацаанд МУЕА-ын тушаалаар АНТАГ-т үүрэг өгсөн 9 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж тайланг Тамгын газарт цахимаар хүргүүлж нэгтгүүлээд байна. Үүнд:

1. МУЕА-ын 2023.12.19-ний өдрийн А/162 дугаар тушаалын дагуу ТАБ-аас 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу 4-р улирлын байдлаар гүйцэтгэсэн "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн", "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө", "Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт /2022, 2023/ үр дүн", Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах", "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх", "Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох", Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулах", "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцооны үр нөлөө", "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"сэдэвт аудитуудын гүйцэтгэлийн явцын мэдээллийг Data.audit.mn цахим системд 14 хоног тутам оруулж АНУЗГ-т /хуучин нэрээр/ Эрсдэлийн удирдлагын газарт тайлагнаж, мэдээлэл солилцож, үүрэг чиглэл авч ажиллалаа. Энэхүү системд МУЕА-ын 2023 оны А/162 тушаалаар баталсан аудитын жагсаалтыг бэлтгэсэн бөгөөд тухайн аудитыг эхлүүлсэн хугацаанаас мэдээллийг оруулан ажиллахаар төлөвлөсөн болно. Тайлангийн жилд төлөвлөсөн 11 аудитыг бүрэн хэмжээнд хэрэгжүүлж, хэрэгжилтийн явцыг цаг тухай бүр мэдээлж ажиллалаа.
2. МУЕА-ын 2023.12.27-ны өдрийн А/172 дугаар тушаалын дагуу ТАБ-ын 2024 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нийт 13 арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг ЗХЭЗГ-т улирал бүр тайлагнаж хамтран ажиллахаар төлөвлөж баталсны дагуу 2024 оны 4-р улирлын байдлаар 13 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, жилийн эцсийн тайланг Тамгын газарт "А" тушаалын хэрэгжилтийн тайлангийн хамт цахимаар хүргүүлж ажилласан.
3. МУЕА-ын 2024.01.15-ны өдрийн А/04 дүгээр тушаалын дагуу ТАГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийн тайланд ХШҮ-ний тайлангаар өгсөн 7 зөвлөмжийг 2024 онд хэрэгжүүлэх, гарсан алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээ авах ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг 2024.09.26-нд үнэлж тайланг Чанарын удирдлагын газарт хүргүүллээ.
4. МУЕА-ын 2024.02.16-ны өдрийн А/09 дүгээр тушаалын дагуу Төрийн аудитын үйл ажиллагааг сурталчлан таниулах иргэд, шалгагдагчтай уулзалт, хэлэлцүүлэг хийх арга хэмжээг 2024.03.15-03.16-ны өдрүүдэд Архангай аймагт 250 гаруй иргэн, 212 төсөв захирагч, санхүү төсөв хариуцсан ажилтнууд оролцуулан зохион байгуулсан. Энэ уулзалт хэлэлцүүлгийн үеэр ҮАГ-аас төрийн аудитын байгууллагын албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг дээшлүүлэх, аудитын үйл ажиллагаанд тулгарч буй сорилт бэрхшээлийг даван туулахад бодлого, чиглэлээр ханган

дэмжлэг үзүүлэх зорилготой “Нэгдсэн сургалт-2024"-ийг зохион байгуулж аудиторууд бүрэн хамрагдав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, Чанарын баталгаажуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ж.Батсайхан, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын аудитын арга зүй хариуцсан менежер Л.Эрдэнэчулуун, сургалтын асуудал хариуцсан менежер М.Цэцэгмаа, бодлого хариуцсан ахлах шинжээч Б.Ариунзаяа, бодлого статистик, дүн шинжилгээ хариуцсан шинжээч А.Алтангэрэл нарын бүрэлдэхүүнтэй баг 14 сэдвээр сургалт хийж, ТАГ-ын 12 албан хаагчид бүрэн хамрагдаж 12 кредит цаг хангасан сертификат гардан авсан.

5. МУЕА-ын 2024.06.18-ны өдрийн А/49 дүгээр тушаалын дагуу "Орон нутгийн сонгуульд оролцох нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах аудитыг МУЕА-ын 2021 оны 69 дүгээр тушаалаар батлсан "Гүйцэтгэлийн заавар аргачлал", 2024 оны А/49 дүгээр тушаалын 1-р хавсралтаар батлсан "Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчээс ирүүлсэн хандивын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гаргах заавар"-ын дагуу гүйцэтгэж дүгнэлтийг 2024.07.31-ны өдрийн 321 дүгээр албан бичгээр улс төрийн 12 намд, 2024.08.09-ний өдрийн 350 дугаар албан бичгээр бие даан нэр дэвшигчид тус тус хүргүүлж ажилласан. АНСДИТХ-ын сонгуулийн хуулийн 37.12 дахь хэсэгт заасны дагуу 2024.09.12-ны өдрөөс улс төрийн нам, бие даан нэр дэвшигчийн хандивын тайлангийн дүгнэлтийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж ажиллав.

6. МУЕА-ын 2024.07.01-ний өдрийн А/52-1 дүгээр тушаалын дагуу Батлсан жагсаалт хэлбэрийн дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хуваарийг Тэргүүлэх аудиторын 2024.09.11-ний А/32 дугаар тушаалаар батлав. АНТАГ-ын шуурхай хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээг шуурхай авч өмнөх оны гэрээг хангалттай үнэлүүлсэн 2 аудитын хуулийн этгээдтэй ажил гүйцэтгэх гэрээг МУЕА ын А/81 дүгээр тушаалын дагуу сунгаж байгууллаа. Санхүүгийн аудитын цахим системд аудиторуудын хуваарийг оруулсан бөгөөд Тэргүүлэх аудиторын 2024.09.02-ны өдөр батлсан завсрын аудитын төлөвлөгөөний дагуу аудитыг эхлүүлж 259 байгууллагын урьдчилсан шатны ажил болон 218 байгууллагын төлөвлөлтийн шатны ажлыг Fas.audit.mn системээр гүйцэтгээд байна. Завсрын аудитын хүрээнд 2024.12.12-ны өдрөөс аймгийн 5-н суманд нийт 25 байгууллагын хамруулан ажиллалаа.

7. МУЕА-ын 2024.09.24-ний өдрийн А/62 дугаар тушаалын дагуу МУЕА-ын 2024.09.24-ний өдрийн А/62 дугаар тушаалын дагуу Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 2024.09.30-ны өдөр Эрсдэлийн удирдлагын газрын ахлах аудитор Ж.Энхтуяад цахимаар хүргүүлэн хянуулсан ба 2024.10.04-ны өдөр МУЕА-ын орлогч С.Батбямба, Тамгын дарга Б.Бундхорол нараар батлуулж, мөрдөн ажилласан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг ТАБ-ын шинэчилсэн төлөвлөгөөний дагуу 9 чиг 12 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг төлөвлөж батлуулан хэрэгжилтийг бүрэн хангалаа.

8. МУЕА-ын 2024.10.08-ны өдрийн А/66 дугаар тушаалын дагуу Эрсдэлийн удирдлага, АНТАГ-ын үйл ажиллагааг хариуцсан МУЕА-ын орлогч С.Батбямбаар 2024.10.04-ны өдөр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, мөрдөн ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Эрсдэлийн удирдлагын

газарт хүргүүлж, үнэлүүлэхээр ажиллаж байна. ҮАГ-ын Тамгын газраас ирүүлсэн 2024.12.10-ны өдрийн 04/52, 2024.12.12-ны өдрийн 04/53 дугаар албан бичгийн дагуу архив, албан хэрэг хөтлөлтийн тайланг 2024.12.13-нд tsetsegmaad@audit.gov.mn, авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг undarmaap@audit.gov.mn, 2024.12.16-нд мэдээллийн ил тод байдлын тайланг nominl@audit.gov.mn, харилцагч талууд болон иргэдийн оролцоог хангах ажлын тайланг audarib@audit.gov.mn и-мэйлээр тус тус хүргүүллээ.

9. МУЕА-ын 2024.11.12-ны өдрийн А/80 дугаар тушаал батлагдсанаас өмнөх хугацааны арга хэмжээний хэрэгжилтийг ҮАГ-ын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.

УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ

ТАБ-ын удирдах ажилтны зөвлөгөөнөөс 2023 оны 12 сарын 22-ны өдөр АНТАГ-уудад 4 үүрэг даалгавар, чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж дэлгэрэнгүй тайланг Тамгын газарт хүргүүлээд байна. Үүнд:

1. УИХ-ын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнгээс өгсөн чиглэлийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал бэлтгэх дэд ажлын хэсэг (Дархан-Уул, Булган, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай, Төв аймгийн ТАГ-ууд)-ийн 2024.01.19-ний хуралдаанд өөрийн бэлтгэсэн 5 саналыг хэлэлцүүлж, бусад аймгийн ТАГ-уудад саналаа солилцсон нэгтгэсэн саналыг бэлтгэхэд идэвхтэй оролцсон. Ийнхүү дэд ажлын хэсгийн хэмжээнд нэгтгэсэн саналыг хууль эрхзүйд нийцүүлэн боловсруулж Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгуулахаар дэд ажлын хэсгийн 2024.01.23-ны өдрийн хуралдаанаар дахин хэлэлцүүлж өөрийн гаргасан 2 саналыг хууль тогтоомжийн үндэслэлийг нарийвчлан томьёолж боловсруулж ҮАГ-т нэгтгэн хүргүүлсэн саналд тусгуулсан. /Төрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгуулах санал Дархан Уул аймаг дахь ТАГ-т хүргүүлсэн/

2. МУЕА-оос өгсөн үүрэг чиглэлийн дагуу Төрийн аудитын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлэх Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацааг өөрчлүүлэх саналыг Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төсөл боловсруулах дэд ажлын хэсгээр уламжлуулан өргөтгөсөн ажлын хэсэгт хүргүүлсэн. Тухайлбал: Төрийн аудитын байгууллагад төсөв захирагчдаас санхүүгийн тайлан ирүүлэх цаглаварт хугацааг одоогийн мөрдөж байгаа хуулийн цаглаварт хугацаанаас 15 хоногийн өмнө ирүүлэхээр буюу хугацааг урагшлуулах саналыг хүргүүлсэн. Ингэснээр санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх хугацаа энэ хэмжээгээр нэмэгдэж аудиторуудын ажлын ачаалал буурах боломжтой гэж үзсэн.

3. Төрийн аудитын газраас төлбөрийн акт тогтоох, албан шаардлагын төсөл боловсруулах явцыг эрхзүйч аудитор, аудитын менежер гэсэн үе шатаар хянаж, хууль эрхзүйн зөрчилгүй байх арга хэмжээг авсан ба шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулахын тулд эрхзүйч аудитор, аудитын менежерүүд хугацаа болон нотлох баримтын хяналтыг хэрэгжүүлж, эрхзүйч аудитор аудитын шийдвэр бүр дээр хувийн хэрэг хөтөлж хяналт тавин ажиллалаа. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудыг оролцоог сайжруулах, шалгагдагч нарт аудитын илрүүлэлт болон алдаа зөрчлийг арилгах талаар цаашид анхаарах асуудлыг танилцуулах аудитын төгсгөлийн уулзалтыг 5 удаа салбар бүрээр зохион байгуулж ажилласан. 2024 онд

нийт 176.8 сая төгрөгийн 66 төлбөрийн акт, 77,705.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 430, албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах 19 албан шаардлагад 3 шатны хяналтыг хэрэгжүүлж шалгагдагч нарт гардуулан өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Харилцагч талуудтай шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах талаар хамтран ажилласнаар төлбөрийн актын 99.1%, албан шаардлагын 99.6%-ийн хэрэгжилтийг хангуулаад байна. 2024 оны 11 дүгээр сард "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангах" сарын аяныг зохион байгуулан хэрэгжилтийг үнэлэн, хэрэгжилтийн тайланг аймгийн ИТХ, Засаг даргад 2024.12.04-ны өдрийн 483, 484 тоот албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.

БҮЛЭГ- VI

ДОТООД АЖИЛ

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТ ХУУЛЬ ЭРХЗҮЙ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь нутгийн удирдлагын ордны А корпусын 3 давхарт 149.6 м.кв талбай бүхий 9 өрөөнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс 12 м.кв талбайтай нэг өрөөг архивын өрөө болгон 3 ширхэг зориулалтын нягтруулсан шүүгээг байрлуулан тохижуулж, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5.5 дахь хэсэгт заасны дагуу галын хор, гал унтраах элс, хүрз, галын булан, галын аваарын схем, чийг дулаан хэмжигч багаж /гегро метр/ зэргийг байршуулан архивын зориулалтаар ашиглаж байна.

Тэргүүлэх аудиторын 2023 оны А/20 дугаар тушаалаар томилогдсон байгууллагын дэргэдэх баримт нягтлан шалгах комиссын 2024 он 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хуралдаанаар 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 274 нэр төрлийн баримт архивд хүлээн авахаар боловсруулж Дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны А/02 дугаар тушаалаар батлууллаа.



ХХНЖ–аар батлуулсан 274 нэр төрлийн баримтын 92.2 хувь буюу 253 баримт нь байнга хадгалах, 1.6 хувь буюу 4 баримт нь 70 жил хадгалах, 6.2 буюу 17 баримт нь түр хадгалах баримт байна.

Байгууллагын архивд хадгалагдаж байгаа нийт баримтыг хадгалах хугацаа нэр төрлөөр нь ангилан байнга хадгалах, түр хадгалах, 70 жил хадгалах гэсэн 3 хэсэгт хуваан тус бүрд нь баримтын нэр төрөл, тоо хэмжээг заасан QR бүхий баримтын заагчийг хийж архивын өрөөнд байрлуулаа.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга хадгалах 333 баримт, түр хадгалах 35 баримтыг цахим болон цаасан суурьтайгаар архивд хүлээн авлаа.

Байгууллагын архив албан хэрэг хариуцсан аудитор Б.Анхтуяа аймгийн Архивын тасгаас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт 20 цагийн сургалтад хамрагдлаа. Байгууллагын архивд байгаа 2003-2015 оны даргын тушаал шийдвэр, төлбөрийн акт, албан шаардлага тэдгээрийн биелэлт зэрэг цаасан суурьтай 6 хадгаламжийн нэгж бүхий архивын баримтыг архив албан хэрэг хөтлөлтийн AMSG программд оруулан цахим болон цаасан суурьтайгаар аймгийн архивын тасагт хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь байгууллагын архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд:

2022-2024 оны 768 нэр төрлийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Үүнд: 2022 оны 245 нэр төрлийн 251 хадгаламжийн нэгж 2023 оны 269 нэр төрлийн 280 хадгаламжийн нэгж, 2024 оны 254 хадгаламжийн нэгж байна.

Байгууллагын цахим архивын баримтыг хадгалах хугацаа нэр төрлөөр нь ангилан үзвэл Байнга хадгалах 674, түр хадгалах 99, 70 жил хадгалах 12 баримт байна.

Байгууллагад 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар нийт 1080 бичиг ирснээс Үндэсний аудитын газраас 10, бусад байгууллагаас 1070 бичиг ирсэн байна. Ирсэн бичгийг тухай бүр байгууллагын ирсэн бичгийн бүртгэлийн дэвтэрт бүртгэн Дарга, Тэргүүлэх аудиторт танилцуулж аудиторуудад шилжүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Ирсэн албан бичгийн 3.1 хувь нь хариутай 96.9 хувь нь хариугүй албан бичиг байна .

Энэ хугацаанд байгууллагаас 493 бичгийг гарснаас 77 бичгийг байгууллагын дотоод сүлжээгээр Үндэсний аудитын газарт, бусад байгууллагуудад 416 бичгийг хүргүүлээд байна.

АВЛЕ системийн албан бичиг хөтлөлт цэсэд 2024 оны 12 сарын 31-ны байдлаар 1573 бичиг бүртгэж холбогдох аудиторуудад системээр шилжүүлэн бичгийг хаах, хариутай бичгийн хариу хүргүүлэх арга хэмжээг авч ажиллалаа

Дарга, Тэргүүлэх аудиторын 66 тушаал гарснаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 48 тушаал, Хүний нөөцтэй холбоотой 23 тушаал гарсан байна. Гарсан тушаалын 68.2 хувь нь А тушаал байгаа бол 31.8 хувь нь Б тушаал байна. Байгууллагын албан хаагчдаас гаргасан нэмэгдэл олгох тухай-7, буцалтгүй тусламж олгох тухай-3, дэмжлэг үзүүлэх тухай-2, бусад-8, нийт-20 өргөдөл, 1 гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Дотоод сургалтын талаар: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд “Мэргэжлийн тасралтгүй Дотоод сургалтын төлөвлөгөө”-ний дагуу 12, төлөвлөгөөт бус 3 нийт 15-н удаагийн сургалтыг танхимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 195 албан хаагч хамрагдлаа.

Цахим сургалтын талаар: Үндэсний аудитын газраас зохион байгуулсан 13 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 156 албан хаагч хамрагдлаа. Үүнээс surgalt.audit.mn системээр төрийн аудиторын ёс зүй, төрийн албан хэрэг хөтлөлт, төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо сэдэвт Е-хичээлийг 10 албан хаагч судалж шалгалтаа амжилттай өгч сертификат авлаа. Аудитын 5 минут, сайн туршлага, МООС-ийн сургалтуудыг бүх албан хаагч судалж мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллалаа. Мөн инфографикийн сургалтад 6 албан хаагч хамрагдаж байна.

Бусад сургалтын талаар: Удирдлагын академийн “Ур дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл” сургалтад 2 хамрагдаж сертификат гардан авсан бол, Аймгийн ЗДТГ-аас Сангийн яам, ММНБИ-тэй хамтран зохион байгуулсан “Архангай аймгийн төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудын зөвлөгөөнд 12, Сангийн яамны “Аудитын дахин инженерчлэл”, “Төрийн сангийн төлбөр тооцооны цахимжилтын чиг хандлага” сэдэвт сургалтад 12 албан хаагч оролцож шинэ мэдлэг, мэдээлэл авлаа. Мөн Дундговь аймагт зохион байгуулсан Төвийн бүсийн мэргэшсэн нягтлан бодогч нарын мэргэжлийн тасралтгүй боловсролын 21 кредит цагийн сургалтад 4, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10-ын сургалтад албан хаагчид тогтмол хамрагдаж мэдлэг, мэдээллээ дээшлүүлэн

ажиллаж байна.

СУРГАЛТЫН ҮР ӨГӨӨЖ

Тайлант онд зохион байгуулагдсан дотоод сургалт болон Үндэсний аудитын газрын сургалтууд нь ажилтнуудад нэн тэргүүнд шаардлагатай сэдвүүдийн захиалгыг өгч хуулийн талаарх мэдлэгээ сайжруулах, хувь хүний хөгжлийн сургалт, цахим болон танхим хосолсон арга хэлбэрээр хичээлийг сонирхолтой байдлаар зохион байгуулаа. Мөн хууль тогтоомжийн шинэчлэл, заавар журам аргачлалын чиглэлээр өгсөн сургалтууд олж авсан мэдлэгээ үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, шинэ мэдлэг мэдээлэл, үр өгөөжийг бий болголоо. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтын үр дүнд хувь хүн өөрийгөө хөгжүүлж байгууллага хамт олны уур амьсгалд эерэг нөлөө үзүүлж, ажил хийх урам зоригийг сэргээж өгсөн маш үр дүнтэй сургалтууд боллоо.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:



- Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг харилцагч талуудад сурталчлан таниулах, иргэд олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2023-2024 оны Санхүүгийн тайлангийн аудитын нээлт, Архангай аймаг дахь төрийн аудитын газар, Үндэсний аудитын газартай хамтран иргэд олон нийтийн дунд зохион байгуулсан “Төрийн аудит иргэдийн амьдралд ”, төрийн албан хаагчид болон төсөв захирагч нарын дунд зохион байгуулсан "Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагаа" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийн мэдээ, 2024 оны 5 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд аудитын зөвлөмжийн хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг даргын зохион байгуулсан "Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтны зөвлөгөөн"-д Төрийн аудитын газраас хэлэлцүүлсэн тайлангийн талаар аймгийн **"АВ" телевизээр** тус тус ярилцлага өгч иргэд, олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлж ажиллалаа.

- 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын төсвийн шууд захирагчийн 143, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 8, сумдын засаг даргын 19, аймгийн ТЕЗ-ийн 2 аудитын нийт 172 хураангуй тайлан, гүйцэтгэл, нийцлийн аудитын 12 дэлгэрэнгүй, хураангуй, визуал тайлан нийт 184 тайланг *www.open.audit.mn* сайтад байршуулж олон нийтэд түгээж ажиллалаа.

- *www.audit.mn* цахим сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 52 мэдээлэл, байгууллагын албан ёсны пэйж /Архангай аймаг дахь Төрийн аудитын газар/ болон фэйсбүүк хуудас /Архангай Аудитын газар/-аар дамжуулан үйл ажиллагаатай холбоотой 52 мэдээлэл, ҮАГ болон Авлигатай тэмцэх газраас мэдээлсэн 156 мэдээллийг олон нийтэд түгээн ажиллалаа.

ХАРИЛЦАГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦОО

Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг хэрэгжүүлэх, аудитын байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагааг харилцагч талуудад ойлгуулж үр ашигтай хамтын ажиллагааг бий болгоход энэхүү үйл ажиллагааны зорилго чиглэгдэнэ. Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас харилцагч талуудтай үр ашигтай хамтран ажиллах хүрээнд жилийн ажлын төлөвлөгөөг баталж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан нөхцөл бүрдүүлэх, шаардлагатай мэдээллийг цуглуулах зорилгоор "*2023-2024 оны санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл ажлыг хангах хөтөлбөр*"-ийг боловсруулан Тэргүүлэх аудитораар батлуулж хөтөлбөрийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Боловсрол шинжлэх ухааны газар, Соёл урлагийн газар, Орон нутгийн өмчийн газар болон аудитыг гэрээний дагуу гүйцэтгэх Бизкон аудит ХХК-ний удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй 2024.01.08-аас 2024.01.17-ний өдрүүдэд уулзалт хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлгээр эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн бодлогын хэрэгжилтийн орон нутгийн нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, онцлог, анхаарах асуудал, 2023 онд шинээр нэмэгдсэн, хасагдсан үндсэн хөрөнгийн бүртгэл, орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт, хадгалалт, ашиглалт, биет бус хөрөнгө болох газрын бүртгэл, тайлагналын онцлог, баримталж байгаа бодлого чиглэл, төсөв санхүүгийн талаар цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцэж санал солилцон ажиллалаа.

2. Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас бүх шатны төсөв захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн 2023 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийх аудитын нээлтийг 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр танхим болон цахим хэлбэрээр зохион байгууллаа. Аудитын нээлтэд 200 гаруй төсөв захирагч, нягтлан бодогч нар оролцсон бөгөөд төрийн аудитын байгууллагаас 2024 оны санхүүгийн тайлангийн аудитад баримтлах бодлого чиглэл, анхаарах асуудал, өмнөх аудитаар илэрсэн зөрчил, шийдвэрийн биелэлт, хэрэгжилтийг хангуулахад харилцагч талуудын оролцоог хангах үр дүнтэй арга хэмжээг танилцуулж санал солилцлоо. 2024 оны 09 сарын 10-ны өдөр "2024-2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудит"-ын нээлтийг хийж гэрээгээр аудит гүйцэтгэгч Бизкон аудит ХХК, Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК, шалгагдагч

боловсрол, эрүүл мэндийн салбарын 85 байгууллагатай гуравласан гэрээг байгуулах арга хэмжээг зохион байгууллаа.

3. Төрийн аудитын байгууллагын 2024 оны зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Архангай аймаг дахь төрийн аудитын газар, Үндэсний аудитын газартай хамтран “Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг сайжруулах уулзалт хэлэлцүүлэг"-ийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт аймаг, сумдын 84 байгууллагын 214 албан хаагчид оролцож төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэж буй аудит, цаашид анхаарах асуудлын талаар санал солилцлоо.

4. Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитыг хуульд заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэж шалгагдагч нарт аудитын тайлан дүгнэлт, шийдвэрийг төгсгөлийн уулзалтыг зохион байгуулж гардуулан өглөө. Төгсгөлийн уулзалтаар илэрсэн алдаа, зөрчлийг танилцуулж, зөрчлийг арилгах, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хугацаанд нь үр дүнтэй хангуулж зөрчил дутагдлыг бүрэн арилгахад хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож хамтран ажиллахаар тохиролцсон. “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө”, “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүн”, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого тогтолцооны үр дүн”, “аймгийн 2022, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт” гэсэн гүйцэтгэл, нийцлийн аудитуудын нээлт, төгсгөлийн уулзалтыг тухай бүр шалгагдагч, хамрагдагч нарыг оролцуулан зохион байгуулж хамтран ажиллалаа.

5. Аймгийн засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, тайлан, хүргүүлсэн шийдвэрийн мөрөөр аймгийн Засаг даргаас “*Төсөв захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудын сургалт, зөвлөгөөн*”-ийг сумдын төсөв захирагч, бүртгэл санхүүгийн нийт 300 гаруй албан хаагчийг оролцуулан 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулаа. Зөвлөгөөний үеэр Төрийн аудитын байгууллагаас “Төсөв захирагчдын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар” төсөв захирагч болон санхүү бүртгэлийн ажилтнуудад

дэлгэрэнгүй мэдээлэл хүргэж, цаашид анхаарах асуудлын талаар оролцогчдын саналыг сонсож хэлэлцүүлэг хийлээ. Тус зөвлөгөөнөөс “Аудит, хяналт шалгалтаар зөрчил дутагдалгүй аймаг болцгооё” гэсэн уриалга гаргаж, бүх шатны төсөв захирагчдад аймгийн Засаг даргаас 6 заалт бүхий албан даалгаврыг хүргүүлээд байна.

6. Аймгийн Засаг даргын санаачилгаар Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороотой хамтран 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан Архангай аймгийн "*Төрийн захиргааны албан хаагчийн нэгдсэн зөвлөгөөн*"-д Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа панелистаар оролцож, 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэсэн дүн, төсөв захирагч, санхүү төсвийн ажилтнуудын сахилга, хариуцлагын зөрчлийн талаар мэдээлэл хийж, Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, хууль эрх зүй, өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулах талаар хэрэгжүүлэх арга хэмжээ, цаашид анхаарах асуудлын саналыг тавьж оролцогчдоор хэлэлцүүлж, зөвлөгөөнөөс гарсан шийдвэрт тусгууллаа.

7. Аймгийн Эрүүл мэндийн газраас 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “*Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн*”-д Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас оролцож эрүүл мэндийн салбарын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын нэгтгэсэн дүн, илэрсэн алдаа, зөрчил, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, алдаа, зөрчлийг таслан зогсоох, арилгахад хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээний талаар хэлэлцүүлж, оролцогчдтой санал солилцлоо. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг Fas системд хэрхэн тайлагнаж, хяналт хэрэгжүүлэх талаар заавар зөвлөмж өглөө.

8. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, чадавхжуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аймгийн ИТХ-аас 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт оролцов. сумдын ИТХ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл хийж, аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн ханган ажиллах талаар заавар зөвлөмж өгч ажиллалаа.

9. Хууль хяналтын байгууллагуудаас сургалт авч мэдээлэл солилцон, зөвлөгөө авч хамтран ажиллалаа. *Тухайлбал:* Сумдын “Хоршоо хөгжүүлэх сан”-аас иргэд, хоршоодод олгосон зээлийн 2023 оны эцэс дэх үлдэгдлийн судалгааг сум тус

бүрээр гаргаж эргэн төлөгдөх хугацаа олон жилээр хэтэрсэн чанаргүй зээлийн үлдэгдлийн судалгааг сум тус бүрээр зээлдэгчийн нэрээр гаргаж аймгийн прокурорын газарт 2024 оны 04 дүгээр сарын 03-ны 183 дугаар албан бичгээр хүргүүлж зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг авах, аудитын явцад авлига, албан тушаалын гэмт хэргийн шинжтэй зөрчил илэрвэл мэдээлэх талаар хамтран ажиллах санал солилцох уулзалтыг 2024.04.03-ны өдөр зохион байгуулсан. Энэ уулзалтын үр дүнд аудитын дүнгээр хууль хяналтын байгууллагаар шалгуулахаар шилжүүлсэн асуудлын шийдвэрлэлтийн талаарх прокурорын газрын мэдээллийг улирал авч ашиглаж хэвшээд байна. Санхүүгийн тайлангийн аудитаар “Татгалзсан” санал дүгнэлт авсан “Ар саравч” ОНӨААТҮГ-тай 2023 оны санхүүтэй холбоотой асуудлыг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний 185 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлж, Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн шалгуулсныг прокуроос хянасан байна.

Шүүхийн байгууллагад хариуцагч нь хүлээн зөвшөөрсөн боловч төсөвт төлөх хугацааг 2-3 жил хэтрүүлсэн 22.9 сая төгрөгийн актыг баталгаажуулах нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж төсөвт төлүүллээ. Аймгийн Шүүхийн тамгын газартай хамтран ажиллаж байгууллагын албан хаагчдад Захиргааны хууль болон аудитын байгууллагад тулгараад байгаа кейсүүдийн талаар асууж тодруулан санал солилцон ажиллалаа. Үүнээс гадна “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр дүн” аудитад албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөнийг тогтоосон шүүгчийн захирамжуудыг гаргуулан авч ашигласнаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар аудитын үр өгөөжийг нэмэгдүүлсэн үр дүнг бий болголоо.

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үндэсний аудитын газрын Тамгын дарга, Тэргүүлэх аудиторын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр баталсан "Төрийн аудитын байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хүрээнд 15 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

- ✓ Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дахь заалтын дагуу Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем болох meduuleg.iaac.mn хөтөлж, 12 албан хаагчдын 2023 оны ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд бүрэн гаргуулан баталгааны маягтыг баталгаажуулан авч, ҮАГ-т тайлагналаа.
- ✓ 2024 оны санхүүгийн тайлангийн аудит болон гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэхдээ нийт 257 байгууллагатай ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлгийг гаргаж, Fas.audit.mn системд оруулж, аудитын ажлын баримтад архивласан. Тайлант хугацаанд албан хаагчид болон байгууллагын талаар ашиг сонирхлын зөрчилтэй асуудал үүсээгүй болно.



Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- ✓ Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 онд Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн 8 контент, 26 шторк мэдээлэл, Үндэсний аудитын газар Авлигатай тэмцэх газартай хамтран бэлтгэсэн 2 брошурыг байгууллагын албан ёсны цахим хуудас болох /Архангай Аудитын газар/ фэйсбүүк хуудсаар дамжуулан 4200 дагагчдад, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын пэйж хуудсаар дамжуулан 498 дагагчдад мэдээллийг хүргэлээ.

Тайлант хугацаанд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан Авлигын эсрэг хуулиар болон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг урилсан агуулга бүхий 2 видео контентыг бэлтгэж байгууллагын пэйж хуудсаар олон нийтэд түгээж ажиллалаа.

- ✓ Иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх "**Цахим нээлттэй хаалганы өдөрлөг**"-ийг 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдөр амжилттай зохион байгуулж, Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалга бүхий контент, гарын авлага тараах материалыг бэлтгэж, иргэд олон нийтэд түгээж сурталчлав. Цахим нээлттэй хаалганы өдөрлөгт давхардсан тоогоор 250 гаруй иргэд оролцож, мэдээллийг 4600 дагагчидтай орон нутгийн **Ингүүн.мн** пэйж хуудас болон байгууллагын албан ёсны цахим хуудас болох Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын пэйж хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд ил тод мэдээллээ.

Харилцагч байгууллагаас авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох 11 асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгааг авлаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагаас авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох 11 асуулга бүхий сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 06 дугаар сард цахимаар

/google.com/forms/ авч ажиллалаа. Судалгааны урьдчилсан дүнгээр нийт 105 иргэн хамрагдсан байна. Төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэхдээ сэтгэл хангалуун байж чадсан уу гэсэн асуулгад 93.3 хувь нь тийм гэж хариулсан байна.



Аудит хийлгэхэд танд болон танай албан хаагчдад хүнд суртал, чирэгдэлтэй асуудал тулгарч байв уу



ТАГ-ын үйл ажиллагаа авлигаас ангид байж чадаж байна уу



Төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэхдээ сэтгэл хангалуун байж чадсан уу





Аудитад хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх талаар танд урьдчилан танилцуулж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн үү

Мөн байгууллагын үйл ажиллагаа авлигаас ангид байж чадаж байна уу гэсэн асуулгад 98.1 хувь нь тийм гэж хариулсан байна.

Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх:

Төрийн аудитын байгууллагын 2024 онд дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцагч талуудын оролцоо, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, ҮАГ-тай хамтран **"Төрийн аудит-Иргэдийн амьдралд"** сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг иргэд олон нийтийн дунд, "Харилцагч талуудын үр ашигтай хамтын ажиллагааг сайжруулах" сургалтыг төрийн байгууллагын санхүү төсөв хариуцсан албан хаагчдын дунд зохион байгуулж, энэ талаарх мэдээллийг орон нутгийн "**АВ телевиз**"-ээр цацаж иргэд олон нийтэд түгээлээ.

Архангай аймгийн Төрийн аудитын газрын 2024 оны шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар 20 минутыг мэдээлэл бэлтгэн 4600 дагагчтай орон нутгийн "**Ингүүн.мн**" пэйж хуудсаар иргэд олон нийтэд түгээж, байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэв.

Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах

Архангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Прокурорын газартай хамтран "Архангай аймгийн хуулийн байгууллагуудын нэгдсэн сургалт, зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, Авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг авч, зөвлөгөөнд оролцогчдын дунд санал асуулга хэлэлцүүлгийг өрнүүллээ. Зөвлөгөөнөөс авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах талаар гаргасан 15 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Архангай аймгийн "Төрийн захиргааны албан хаагчийн нэгдсэн зөвлөгөөн"-д хамтран оролцож, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн болон төрийн албаны сахилга хариуцлагын талаар мэдээлэл хийлээ.

Аймгийн Прокурорын газраас Авлигын тухай хуулиар сургалтыг амжилттай зохион байгууллаа. Мөн 2024 оны 4 дүгээр сард аймгийн Ерөнхий прокурор Ц.Сүхбат, Ерөнхий прокурорын орлогч С.Эрдэнэтуяа нартай санхүү төсвийн эрсдэлтэй асуудлыг бууруулах уулзалт хийж, Хоршоо хөгжүүлэх сангийн найдваргүй зээлийн авлагын аймгийн хэмжээний судалгааг гарган нэгтгэн хүргүүлж, цаашид хамтран ажиллах санал солилцов.

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны авлигын эсрэг төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдад Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын талаар сургалтыг амжилттай зохион байгуулав.

Авлигын тухай хууль болон Хөрөнгө, орлогын мэдүүлэг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах журмаар байгууллагын албан хаагчдын дунд **"АЛТАН ХОНХ"** танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж, тэргүүн байранд ахлах аудитор Н.Алтантуяа, дэд байранд Н.Дашмягмар, гутгаар байранд Б.Анхтуяа нар шалгарлаа.

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь МУЕА-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/94 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги 2020-2023"-ийг хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Стратеги төлөвлөгөөг ҮАГ-аас шинэчилж батлаагүй байгаа бөгөөд тайлант онд төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах талаар дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

1. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторааар “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратеги”-ийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.
2. Төрийн аудитын байгууллагын 2024 онд дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцагч талуудын оролцоо, төрийн аудитын

байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах стратегийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор Үндэсний аудитын газар нь Архангай аймаг дахь төрийн аудитын газартай хамтран “ТӨРИЙН АУДИТ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД” сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2024.03.15-ны өдөр аймгийн иргэд, олон нийтийн дунд зохион байгууллаа. Уулзалт хэлэлцүүлэгт 200 гаруй иргэд оролцсон юм.

Мөн “Нэгдсэн сургалт-2024”-ийн хүрээнд Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, албан хаагчдын мэдлэг, чадвар, хандлагыг дээшлүүлэх, аудитын үйл ажиллагаанд тулгарч буй сорилт бэрхшээлийг даван туулахад бодлого чиглэлээр ханган дэмжлэг үзүүлэх зорилгоор албан хаагчийн чадавхыг бэхжүүлэх 12 цагийн сургалтад нийт 12 албан хаагч хамрагдаж сертификат авлаа.

3. Төрийн аудитын байгууллага иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлж, аудитад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар аудитын үр нөлөөг дээшлүүлэхэд Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн аудитын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо” сэдэвт 1 кредит цагийн цахим сургалтад 2 албан хаагч хамрагдаж сертификат авлаа.
4. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа “М смарт” академийн “Инфографикийн мэдлэг олгох” 45 кредит цагийн сургалтыг амжилттай төгсөж албан хаагчдад аудитын тайлан, мэдээллийг иргэдэд зориулсан ойлгомжтой хэлбэрээр бэлтгэх анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа. Мөн ҮАГ-ын 2024 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж буй инфографикийн сургалтад 6 албан хаагч хамрагдаж байна. Үүний үр дүнд төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон аудитын тайлангуудыг иргэд, олон нийт уншиж танилцахад хялбар инфографик, визуал хэлбэрээр бэлтгэн олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын мэдээллийн самбар, пэйж хуудас зэргээр дамжуулан түгээж тэдний саналыг хүлээн авч хэвшлээ.

5. www.audit.mn цахим сайтад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 52 мэдээлэл, байгууллагын албан ёсны пэйж хуудас /Архангай аймаг дахь Төрийн аудитын газар/-аар дамжуулан үйл ажиллагаатай холбоотой 52 мэдээлэл, Үндэсний аудитын газар болон Авлигатай тэмцэх газраас мэдээлсэн 156 мэдээллийг олон нийтэд түгээн ажиллалаа.
6. 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын төсвийн шууд захирагчийн 143, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 8, сумдын засаг даргын 19, аймгийн

ТЕЗ-ийн 2 аудитын нийт 172 хураангуй тайлан, 1 визуал тайлан, Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, ОНХС-ийн 2023 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө, Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө аудитын тайлан, Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт үр дүн гүйцэтгэлийн аудитын, Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр нөлөө, УИХ болон аймаг сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл, үр нөлөө, Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайлан нийт 184 тайланг ***www.open.audit.mn*** сайтад байршуулж олон нийтэд түгээж ажиллалаа.

7. Байгууллагын энэ оны үйл ажиллагааны талаар “Архангайн амьдрал сонин”-д 2 удаа мэдээлэл бэлтгэж нийтлүүллээ. Нийтлэлд 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын талаар болон хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас нэгтгэн удирдаж байгаа “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр, дүн үр нөлөө” сэдэвт улсын хэмжээнд гүйцэтгэж байгаа нэгдсэн удирдамжтай аудитын явцын талаар болон бусад гүйцэтгэж байгаа аудитын талаар мэдээллээ.

8. Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв сонгоход аймгийн ИТХ, иргэд, олон нийтээс цахимаар санал асуулга авч ажиллалаа. Нийт 13 сэдвийн санал ирснээс “Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт үр өгөөж”, “Нэгдсэн эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж” сэдвүүдийг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/104 дүгээр тушаалаар баталсан “Аудитын сэдэв сонгох ажиллагааны журам”-д заасны дагуу ҮАГ-ын Стратеги төлөвлөлтийн газарт Тэргүүлэх аудиторын 2024.07.09-ний өдрийн 291 тоот албан бичгээр хүргүүллээ.

9. Тодорхой сэдвээр хийх аудитад эрсдэл бүхий асуудлыг тогтоох зорилгоор улсын хэмжээнд гүйцэтгэж байгаа нэгдсэн удирдамжтай “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр, дүн үр нөлөө” сэдэвт аудитын хүрээнд УБ хот 21 аймгийн иргэд олон нийтээс Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүн, үр нөлөө, иргэдэд амьдрал, орон нутгийн хөгжилд эерэг өөрчлөлт бий болсон эсэх, цаашид хэрхэн сайжруулах талаар улсын хэмжээнд цахим сүлжээ ашиглан санал асуулга авч үр дүнг нэгтгэлээ. Санал асуулгад нийт 8055 иргэн хамрагдсанаас судалгаанд оролцогчдын 60 хувь нь

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-д өөрийн саналаа өгсөн, 45 хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, чанарт хангалттай гэсэн үнэлгээ өгсөн бол судалгаанд оролцогчдын тэн хагас нь ОНХС-ийн 2023 онд баталсан хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон гэж хариулсан байна. Мөн нэгдсэн удирдамжтай улсын хэмжээнд гүйцэтгэж буй "Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын хүрээнд хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг тандах зорилгоор санал асуулга авсан бөгөөд үр дүнг нэгтгэн дүгнэж, аудитын нэгдсэн тайланд тусган иргэд олон нийтэд мэдээлэхээр байна.

10. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, төрийн аудитын үйл ажиллагаанд иргэд, харилцагч талуудын оролцоог сайжруулах зорилгоор байгууллагын "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 12 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгууллаа."Бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны өдөр-2024" арга хэмжээний үеэр Төрийн аудитын байгууллагын эрхэм зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, 2024 онд хийж гүйцэтгэсэн аудитын үр нөлөө, хүргүүлсэн шийдвэрийн биелэлтийн үр дүн болон харилцагч байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг иргэдэд хэвлэмэл /брошур, тайлан/ болон видео /ухаалаг дэлгэцээр бичлэг үзүүлэх/ хэлбэрээр танилцуулаа. Фейсбүүкт олон дагагчтай мэргэжлийн сэтгүүлчийн хөгжүүлдэг Ингүүн.мн пейж хуудсаар цахим хэлбэрээр нээлттэй мэдээллийг түгээж "Цахим нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулаад байна. Энэхүү арга хэмжээ нь төрийн аудитын байгууллагын талаар сонирхсон мэдээллийг иргэд заавал биеэр ирж авах бус цахим хэлбэрээр хаанаас ч хэн ч авах боломжийг олгосон үр дүнг бий болголоо.

БУСАД ДОТООД АЖЛЫН ТАЛААР

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын даргын баталсан "2024 оны нийгмийн хамгаалал, дотоод ажлын төлөвлөгөө"-ний дагуу 6 ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 100 хувь зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

"Хүрээлэн буй орчноо хамгаалах хайрлая" хог, цас цэвэрлэх, мод тарих ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулаа.

"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын хамт олон 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Сангийн толгой гүүр Чингэсийн хүрээ жуулчны баазын урд 13 ширхэг улиас модыг тарьж, 7 хоног бүрийн 5 дахь өдөр мод усалгааны ажлыг хийж байна.

зохион байгууллаа.

Байгууллагын албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжих зорилгоор аймгийн Биеийн тамир спорт хорооны газартай гэрээ байгуулж, 7 хоног бүрийн 4 дэх өдөр аймгийн ИТХ-ын албан хаагчидтай хамтран заал авч байна.

Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулаа.

Байгууллагын ажилтан, алба хаагчдыг “Бриллиант” эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулаа.Үзлэгээр цусан дахь сахрын хэмжээ тодорхойлох, хэвлийн болон бамбайн хэт авайн оношилгоо, зүрхний цахилгаан бичлэг, дотор, тархи толгойны MRI, Компьютер томограф, урологи зэрэг нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийгдлээ.

Архангай аймгийн бүртгэл, санхүү, эдийн засгийн ажилтны баяр-2024 арга хэмжээг зохион байгууллаа.

Аймгийн санхүүчдийн дунд “Санхүүчид дуулж байна” дууны уралдаан, спортын 4 төрөлт арга хэмжээ, хүндэтгэлийн хүлээн авалтыг зохион байгуулав.

Байгууллагын газрын асуудлыг шийдвэрлүүллээ.

Аймгийн засаг даргад байгууллагын албан конторын барилгын газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгууллаа.

БҮЛЭГ- VII

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Санхүүгийн үйл ажиллагааны талаар:

Байгууллагын 2024 оны 12 дугаар сард 964.5 сая төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, төсвийн гүйцэтгэлээрсая төгрөгийн санхүүжилт хийгдэжүндсэн үйл ажиллагааны зардалд 964.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн зарцуулалт 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.



2024 оны гүйцэтгэлээр нийт төсвийн 71.1 хувь буюу 685.6 сая төгрөгийг цалинд, 8.8 хувь буюу 85.3 сая төгрөгийг ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлд, 2.0 хувь буюу 19.3 сая төгрөгийг хангамжийн материалын зардалд, 6.9 хувь буюу 66.9 сая төгрөгийг тавилга эд хогшлын зардалд, 3.0 хувь буюу 29.3 сая төгрөгийг томилолтын зардалд, 3.4 хувь буюу 33.1 сая төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, 1.4 хувь буюу 13.8 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.2 хувь буюу "Төрийн аудитын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.3 дах заалтын дагуу 4 албан хаагчид 21.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 5.9.5 дахь заалтын дагуу 1 албан хаагчид 0.5 сая төгрөгийн тусламж , 6.5 дах заалтын дагуу 4 албан хаагчид 1.2 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт, ахмадын баяраар ахмадад хүндэтгэл үзүүлэхэд 0.8 сая төгрөг, албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулахад 5.8 сая төгрөг, хүүхдийн баярт зориулж 1.5 сая төгрөг" нийт 30.8 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд зарцуулж, 0.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар:

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар 2024 оны 12 сарын байдлаар аудитын үйлчилгээний төлбөр 2023 оны 51.0 сая төгрөг 2024 оны 94.9 сая төгөргийг төвлөрүүлснээс "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК болон "Бизкон аудит" ХАК-ийн санхүүгийн тайлангийн аудит хийсэн үйлчилгээний төлбөрт 77.9 сая төгрөгийг шилжүүлж, Үндэсний аудитын газарт нэмэлт санхүүжилтийн орлогыг Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын батлагдсан "Төсвийн зардлыг хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах хяналт тавих журам"-ын дагуу зарцуулах хүсэлт хүргүүлэн Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 224 дугаар тушаал, МУЕА-ын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/102 дугаар тушаалыг үндэслэн 2 албан хаагчид 10 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 6.7 сая төгрөгөөр тавилга эд хогшил худалдан авахад зарцуулан 51.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Үндсэн хөрөнгийн тооллогын талаар:

Дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/47 тоот тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллогын комиссыг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тооллогын комисс байгууллагын дансанд бүртгэлтэй ашиглагдаж буй хөрөнгийг эзэмшигч тус бүрийн эд хөрөнгийн карттай нэг бүрчлэн тулгаж, ашиглалтын байдал, чанар зэргийг үнэллээ. Тооллогын комиссоос Өмч хамгаалах байнгын зөвлөлд дараах 2 саналыг хүргүүлсэн.Үүнд:

- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, одоо ашиглагдаж байгаа 2 нэр төрлийн 5 ширхэг 6.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 1 нэр төрлийн 2 ширхэг 0.4 сая төгрөгийн тавилга эд хогшил нийт 6.7 сая төгрөгийн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох
- Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй 2 нэр төрлийн 14 ширхэг 4.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшилд бүртгэлтэй хөрөнгүүдийг акталж данснаас хасах арга хэмжээг авах

Шилэн данс:



Төрийн аудитын газар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрт дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар олгосон ээлжийн амралт, үр дүнгийн урамшуулалтай холбоотой зардлын гүйцэтгэлийг тухай бүр мэдээлж мөн шилэн дансны танилцуулах самбараар иргэд олон нийтэд мэдээлсэн. Шилэн дансны сайтад тухай бүр мэдээлэх 108 мэдээ, жил бүр мэдээлэх 8, хагас жил мэдээлэх 4, сар бүр мэдээлэх 48 нийт 167 мэдээг хугацаанд 1 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлэн 3 мэдээлэл тайлагнах хугацаа болоогүй байна.

БҮЛЭГ - VIII

ДҮГНЭЛТ, САНАЛ

ДҮГНЭЛТ, САНАЛ

Тайлант хугацаанд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд 2024 онд төсвөөс 964.5 сая төгрөгийн санхүүжилт авч, нөөц бололцоогоо бүрэн дайчлан төлөвлөсөн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

- "Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангахад харилцагч талуудын оролцоог сайжруулах" зорилтын хүрээнд дэд төлөвлөгөөг дарга, тэргүүлэх аудиторын А/20 тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллав.
- Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 2024 онд 9 чиг үүрэг, 12 зорилтын хүрээнд нийт 38 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 1 арга хэмжээ 95 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Тайлант хугацаанд 257 санхүүгийн тайлангийн, 5 гүйцэтгэлийн, нийцлийн 7, нийт 269 аудитыг хийж гүйцэтгэлээ.
- Тайлант онд гүйцэтгэсэн аудитаар нийт 92,131.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс бүртгэл тайлагналтай холбоотой 12,888.3 сая төгрөгийн 100 алдааг аудитын явцад залруулж, 176.8 сая төгрөгийн төлбөрийн 66 акт тогтоосноос хэрэгжилт 98.5 хувь, 77,705.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах 430 албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 92.3 хувь, 319.7 сая төгрөгийн 19 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагын хэрэгжилт 100 хувь, 1,041.1 сая төгрөгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах 151 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 89.4 хувьтай байна. ТАГ-аас 2024 оны 4 дүгээр улиралд гүйцэтсэн гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн хугацаа болоогүй буюу хэрэгжих шатандаа байна.
- Харилцагч талуудын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүллээ.
- Нэгдсэн болон дотоод сургалтад албан хаагчдыг бүрэн хамруулж, мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллалаа.
- Аудитын үр дүнд нийт 11,765.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, санхүүгийн бус 59 үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлсэн төсвөөс авсан санхүүжилтийн нэг төгрөгийн хариуд 12 төгрөг 19 мөнгөний үр өгөөжийг бий болголоо.

------ o0o -------